



“БЭРХ УУЛ” ХК – ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 02

Улаанбаатар

Г

Г

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

“Бэрх Уул” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэж, дийлэнх олонхийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Бэрх Уул” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 сарын 29-ний Баасан гарагт 09:00 цагт Хан Уул дүүрэг, 15-р хороо, Модерн Таун хотхон дахь “Бэрх Уул” ХК-ын оффисын хурлын танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай:
 - a. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх аудитийн хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах
 - b. 2022 оны ажлын төлөвлөгөө, зардлын төсвийг хэлэлцэн батлах
 - c. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
 - d. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
 - e. Хөрөнгө шилжүүлэх, худалдах талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
 - f. Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний талаар гаргасан ТУЗ-ын шийдвэрийг хэлэлцэн батлах
 - g. Зээл, өр төлбөрийн талаар гаргасан ТУЗ-ын шийдвэрийг хэлэлцэн батлах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах Бүртгэлийн өдрийг 2022 оны 04 дугаар сарын 8-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2022

- оны 03 дугаар сарын 24-ны өдөр буюу пүрэв гарагт, өдөр тутмын 2-оос доошгүй сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээллэх. Энэ мэдээллийг анх зар хүргэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 04 сарын 11-ны өдөр дахин зар гаргахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримттай 2022 оны 03 сарын 21-ний өдрөөс хойш 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд Хан-уул дүүрэг, 15 хороо, Махатма гандигийн гудамж, Модерн Таун хотхон, 201 тоотод ирж танилцах эрхтэй болохыг дурьдсугай.
 6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг 03 дугаар хавсралтаар баталсугай.
 7. Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах өдрийг хүртэл байхаар тогтсугай.
 8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Гүйцэтгэх захирал А.Даваажав, хурал зохион байгуулах комиссын даргаар А.Даваажав, гишүүдээр О.Мөнхгэрэл, Б.Баярцэнгэл, Тооллогын комиссын даргаар Д.Уянга, гишүүдээр Л.Тэмүүжин, Ё.Амарбат нарыг тус тус томилсугай

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



Р.БАДРАХ